



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/84

Хашаат

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17.1.2, 18.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Тус сумын нутаг дэвсгэрт 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдах Алаг овооны тахилга наадмын үед хүүхдийн эрх ашгийг хамгаалах, эрүүл мэнд аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих, хүүхдийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, хурдан морины уралдааныг Сумын Засаг даргын захирамжийн дагуу зохион байгуулсугай.

2. Зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Хурдан морины уралдааныг холбогдох хууль тогтоомж болон "Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавигдах шаардлага "MNS6264:2018 стандартыг бүрэн хангаж, гэнэтийн ослын даатгалд хамруулж, уралдааны үед хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж ажиллахыг зохион байгуулагч иргэд, оролцогч талууд, уяачдын холбооны тэргүүлэгчдэд тус тус үүрэг болгосугай.

4. Хурдан морины уяач, уралдаанч хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй гурвалсан гэрээг байгуулах, уралдаанч хүүхдийн эцэг эхийн зөвшөөрөл авах, хурдан морины уралдааны явцад уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, хяналт тавьж ажиллахыг Толь багийн засаг дарга (Д.Дашцэрэн), хэсгийн төлөөлөгч (Ч.Эрдэнэбулган), Эрүүл мэндийн төвийн эмч (Д.Дашсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр зөвлөмж, мэдээ мэдээллийг эцэг эх, асран хамгаалагч, уяачдад өгч ажиллахыг Хүүхэд хамгааллын хамтарсан баг, гишүүдэд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  ЗАСАГ ДАРГЫН  
Ц.ДЭЛГЭРСАЙХАН

Сумын Засаг даргын  
20<sup>23</sup> оны 06 дугаар сарын 26-ны өдрийн  
112х дугаар захирамжийн хавсралт

АЛАГ ОВООНЫ ТАХИЛГА НААДАМД ХЯНАЛТ ТАВИХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Д.Дашцэрэн (Толь багийн засаг дарга)

Гишүүд: Ч.Эрдэнэбулган (Хэсгийн төлөөлөгч)

Д.Дашсүрэн (Эрүүл мэндийн төвийн их эмч)